

# „АЖ АХУЙ ЭРХЛЭХ НЬ ГЭРЭЭГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БИШ“ Чех улсад аж ахуй эрхлэх талаарх үндсэн мэдээлэл

**АЖ АХУЙ ЭРХЛЭХ (БИЗНЕС)** нь хуулиар тодорхойлогдоо ашиг олох зорилгоор бие даан, өөрийн нэрийн өмнөөс болон өөрийн үүрэг хариуцлагаар тасралтгүй явуулж буй үйл ажиллагаа юм.

*Тасралтгүй хөдөлмөр эрхлэх - үйл ажиллагаагаа давтагдах.*

*Хувиараа хөдөлмөр эрхлэх - та ажлаа өөрөө зохион байгуулж, зардлаа өөрөө хариуцна (жишээ нь, багаж хэрэгсэл эсвэл хувиараа үйл ажиллагаа эрхлэх газар).*

*Ашиг орлог - үйл ажиллагааныхаа төлбөрийг цалин хэлбэрээр бус харин тайлан тооцоогоор (фактур) гаргадаг.*

## Х

**ГЭРЭЭГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ** – ажилтан болон ажил олгогч хоёрын хооронд байгуулсан хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ юм.

**! АНХААР ! АЖ АХУЙ ЭРХЛЭХ НЬ ГЭРЭЭГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БИШ. ЧЕХИЙН ХУУЛЬ ЗӨРЧИХӨӨС СЭРГИЙЛЖ, АЖ АХУЙ ЭРХЛЭХЭД ХЭРЭГТЭЙ БҮХ ШААРДЛАГЫГ ХАНГАХ ЁСТОЙ.** Хэрвээ Хөдөлмөрийн хяналтын газраас шалгалт ирвэл өндөр торгууль ногдуулна.

Чех улсад **аж ахуй эрхлэх төрлүүд** (захиргааны төв байгууллага нь Аж Үйлдвэр, Худалдааны яам):

- *хувиараа хөдөлмөр эрхлэх эрхийн зөвшөөрлийн үндсэн дээр – хувь хүн аж ахуй эрхлэх.* Хувиараа үйл ажиллагаа эрхлэлтийг худалдааны хуулиар зохицуулдаг бөгөөд энэ хамгийн түгээмэл хэлбэр юм.
- *Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр, жишээлбэл „хуулийн этгээдүүд оролцох“ (худалдааны компани эсвэл хоршоо) – хуулийн этгээдүүд аж ахуй эрхлэх.*

**! ШВАРЦСИСТЕМЭЭС БОЛГООМЖИЛ !** – энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэгчийн (OSVČ) үүргийг албан ёсоор гүйцэтгэдэг боловч, үнэн хэрэгтээ өөрийн үйлчилгээ/барааг ганцхан хэрэглэгчд үзүүлэх нөхцөл юм. Хэрэв энэ үйлчлүүлэгч нь хувиараа аж ахуй эрхлэгчийн ажил олгогч шиг аашилж - түүнд юу хийхийг хэлж, түүнд хөдөлмөр эрхлэхэд ашиглах багаж хэрэгсэл, материалаар хангаж, ажлын байр, ажлын хэрэгслээр хангаж байвал энэ нь шварцсистем байх боломжтой ба энэ хууль гуйвуулалт юм!

БНЧУ-д хуулиар шууд хориглоогүй эсвэл худалдаанаас хасагдаагүй үйл ажиллагааны чиглэлээр аж ахуй эрхлэх боломжтой. *Хэрэв та насанд хүрсэн, хуулийн болон эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай болон тодорхой үйл ажиллагааны чиглэлээр (мэргэжлийн ур чадвар, туршлага) бусад нөхцөлийг хангасан бол аж ахуй эрхлэлтэй эхлүүлэх боломжтой.*

**Та аж ахуй эрхлэхийг хүсэж байвал хувиараа аж ахуй эрхлэх эрх авах хэрэгтэй.** Аж Үйлдвэрийн захиргааны эсвэл Чех шуудангийн Czech POINT (сонгосон салбарууд) дээр бүртгэлийн маягтыг бөглөсний дараа авах боломжтой. Үүний зэрэгцээ 1000 крон захиргааны хураамж төлөх ёстой.

- Шаардлагатай бичиг баримтууд:
  - Иргэний үнэмлэх.
  - Захиргааны хураамж төлсөн баримт.
  - Чех улсад оршин суух зөвшөөрөл.



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.

# „АЖ АХУЙ ЭРХЛЭХ НЬ ГЭРЭЭГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БИШ“ Чех улсад аж ахуй эрхлэх талаарх үндсэн мэдээлэл

- Мөн шаардлагатай байж болох баримтууд:
  - Ял шийтгэлтэй эсэх лавлагаа (гадаадын иргэн харьяалагддаг улсын эрх бүхий байгууллагаас авна, дээд тал нь 3 сар), албан ёсоор орчуулсан байх ёстой.
  - Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь тухайн байгууламжид аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл.
  - Мэргэжлийн ур чадвар шаардлагатай тохиолдолд мэргэжлийн ур чадварын баталгаа эсвэл гэрчилгээг мөн өгөх ёстой.

**Таны аж ахуй эрхлэхийг нотлох баримт бол худалдааны бүртгэлийн хуулбар юм.** Танд ІСО - БҮРТГЭЛИЙН ДУГААР өгнө, мөн та түүгээрээ танигдана.

## **Хувиараа аж ахуй эрхлэх - аж ахуй эрхлэх тухайгаа мэдэгдэх (8 хоногийн дотор):**

**1, Эрүүл мэндийн даатгал** - эрүүл мэндийн даатгал төлөлтийн улмаас таныг OSVČ буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч ангилалд оруулна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч бүр эрүүл мэндийн даатгал төлөх ёстой (2022 оны доод хэмжээ нь 2627 крон байхаар тогтоосон).

**2, Дүүргийн Нийгэм хамгааллын газар (OSSZ)**- тэтгэврийн даатгалын улмаас. 2022 оны доод хэмжээг 2841 крон гэж тогтоосон.

Та эрүүл мэндийн даатгалын газар болон OSSZ-аас даатгалын шимтгэлийг төлөхийг заасан захидал хүлээн авах болно (эсвэл таныг захиргааны байгуулагд ирэхийг хүсэх болно). Даатгалын шимтгэлийн урьдчилгааг сар бүр төлөх ёстой ба аж ахуй эрхлэлтэй эхлүүлсэн сарыг оруулж төлнө.

**3, Татварын алба** - татварын төлбөрийн улмаас. Та **иргэний бүртгэлд бүртгүүлэх өргөдлийн** маягтыг бөглөнө үү. Дараа нь танд DIC дугаар - татварын үнэмлэхийн дугаар олгох болно. Та шуудангаар бичгээр хүлээн авах болно.

**! АНХААР ! – ТА ЖИЛ БҮР ТАТВАРЫН МЭДҮҮЛЭГ МЭДЭГДЭХ ЁСТОЙ** - та орлогын албан татварыг 15% төлж мөн урьдчилгаа төлбөрийг тооцно (Үндэслэл нь эрүүл мэндийн даатгалын татварын хэмжээний дүнгийн тойм болон OSSZ-ийн орлого, зарлагын тойм юм).

## **ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ Ч ГЭСЭН АЖ АХУЙ ЭРХЛЭХ БОЛОМЖГҮЙ. ТА ОРЛОГОО ҮРГЭЛЖ БАТЛАХ ХЭРЭГТЭЙ.**

БНЧУ-д гадаадын иргэн аж ахуй эрхлэх зорилгоосоо өөр төрлийн оршин суух зөвшөөрөлтэй бол аж ахуй эрхлэх боломжтой боловч оршин суух анхны зорилгоо үргэлж биелүүлэх ёстой. Жишээлбэл: Хэрэв та оюутны визний үндсэн дээр оршин суух зөвшөөрөл авсан бол цаашид ч суралцах ёстой.

## **Хэрэв та өөрийн оршин суух зорилгоо, аж ахуй эрхлэх зорилгоор солихыг хүсвэл, дараах тохиолдолд өөрчлөх хүсэлт гаргаж болно:**

- та урт хугацааны оршин суух хүчинтэй зөвшөөрөлтэй - гэхдээ зөвхөн БНЧУ-ын нутаг дэвсгэрт 5 жил оршин суусны дараа,
- та гэр бүл нэгтгэх зорилгоор оршин суух хүчинтэй зөвшөөрөлтэй - гэхдээ зөвхөн БНЧУ-ын нутаг дэвсгэрт 3 жил оршин суусны дараа эсвэл 18 нас хүрсэн бол.



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.

# „АЖ АХУЙ ЭРХЛЭХ НЬ ГЭРЭЭГЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БИШ“ Чех улсад аж ахуй эрхлэх талаарх үндсэн мэдээлэл

## Чехийн иргэдтэй адил нөхцөлд Чех улсад аж ахуй эрхлэх боломжтой:

- Европын холбооны гишүүн улс эсвэл Европын эдийн засгийн бүсийн хэлэлцээрийн өөр улсын иргэд эсвэл Швейцарын холбооны иргэд.
- Урт хугацааны аж ахуй эрхлэх визний үндсэн дээр гуравдагч орны иргэд - гэхдээ та урт хугацааны визний зорилгоор оршин суух боломжтой гэдгээ батлах ёстой.
- Хэрвээ БНЧУ-д байнга оршин суух эрхтэй бол.

## ТА БНЧУ-Д АЖ АХУЙ ЭРХЛЭХ ТАЛААРХ БУСАД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ЭНДЭЭС АВАХ БОЛОМЖТОЙ:

[www.mpo.cz](http://www.mpo.cz), [www.businessinfo.cz](http://www.businessinfo.cz), [www.mpsv.cz](http://www.mpsv.cz), [www.mfer.cz](http://www.mfer.cz), [www.cssz.cz](http://www.cssz.cz), [www.mzcr.cz](http://www.mzcr.cz)

**ХЭРВЭЭ ТА НӨХЦӨЛ БАЙДАЛДАА ИТГЭЛГҮЙ БАЙВАЛ ГАДААД ИРГЭДЭД ТУСЛАХ ТӨВӨӨС ЗӨВЛӨГӨӨ АВАХ НЬ ДЭЭР, БИД ТАНД ТУСЛАХДАА БАЯРТАЙ БАЙХ БОЛНО. УУЛЗАЛТЫН ЦАГАА УРЬДЧИЛАН ТОВЛООРОЙ.**



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.